



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх
хугацааг сунгах тухай

Эдийн засаг, бизнесийн орчин нөхцөл, даатгалын компаниудын санхүү, төлбөрийн чадварын байдлыг харгалзан, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 355 дугаар тогтоолын дагуу даатгалын компаниудын дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлэх хугацааг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ

ГҮЙЦЭТГЭГЧ, ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД